

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2025 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК УБГД:9022001010, ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	350,463,539 ширхэг		
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ц.Хангал /Захиргааны мэргэжилтэн/ Х.Эрдэнэбүрэн /Захиргаа санхүүгийн газрын захирал/		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	12/31/2025	06/30/2026
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	1,259,527,516,142.7	1,450,351,259,347.43
	Эргэлтийн бус хөрөнгө	25,252,637,428.58	24,532,078,025.27
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,284,780,153,571.5	1,474,883,337,372.70
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр	1,193,815,432,420.2	1,376,154,520,478.33
	Урт хугацаат өр төлбөр	960,250,351.36	960,250,351.36
	Эздийн өмчийн дүн	90,004,470,799.57	97,768,566,543.01
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,284,780,153,571.5	1,474,883,337,372.70
Орлогын тайлан	Үзүүлэлт	12/31/2025	06/30/2026
	Борлуулалтын орлого (цэвэр)	10,744,739,531.52	7,643,244,929.78
	Борлуулалтын өртөг	5,876,432,371.22	3,277,623,681.01
	Нийт ашиг(алдагдал)	4,868,307,160.30	4,365,621,248.77
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	35,389,698,119.03	25,543,968,578.59

	Орлогын татварын зардал	3,568,299,639.05	2,555,736,700.99
	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	31,821,398,479.98	22,988,231,877.60
	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Орлогын нийт дүн	31,821,398,479.98	22,988,231,877.60
	Үзүүлэлт	12/31/2025	06/30/2026
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч	35,046,353,900.00	35,046,353,900.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,987,924,558.50	19,976,576,033.50
	Эздийн өмчийн бусад хэсэг /Эрсдэлийн сан/	2,217,282,386.53	2,700,134,123.99
	Хуримтлагдсан ашиг	32,752,909,954.54	40,045,502,485.52
	Нийт эздийн өмчийн дүн	90,004,470,799.57	97,768,566,543.01
	Үзүүлэлт	12/31/2025	06/30/2026
Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	426,779,004,071.33	193,307,263,500.27
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(53,631,252,072.52)	(11,122,318,741.46)
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(16,186,706,237.35)	(14,945,533,177.84)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	87,376,236,482.15	176,877,171,505.54
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	816,117,554,232.93	1,203,493,790,715.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,203,493,790,715.8	1,380,370,962,220.2
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэх болно.			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцоож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт		
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь Цэвэр ашгийн хувь Өөрийн хөрөнгийн өгөөж Нийт хөрөнгийн өгөөж	14.17% 74.61% 23.51% 1.56%
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа Түргэн хөрвөх чадварын харьцаа Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	1.05 1.05 14.09
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	• Үнэт цаасны арилжаа: Дотоодын үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индекс 2026 оны эхний хагас жилд 55,133.21 нэгжид хүрч өссөн бол доод үзүүлэлт нь 50,093.30 нэгж, дундаж үзүүлэлт нь 52,375.79 нэгж байсан бол энэ оны 6 дугаар сарын 30-ны байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,785.42 нэгж буюу 7.69 хувиар өсөж, 53,031.59 нэгж болсон байна.	

	Зах зээлийн үнэлгээ 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 13.69 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.55 тэрбум төгрөг буюу 12.84 хувиар өссөн байна. Харин үнэт цаасны арилжааны хувьд, 2026 оны эхний хагас жилд нийт 123 удаагийн нийт 800.39 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулсан байна. Тодруулбал, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 129 хувьцаат компанийн 258.25 сая ширхэг хувьцааг 139.99 тэрбум төгрөгөөр, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 702.56 мянган ширхэг үнэт цаасыг 68.43 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.41 сая ширхэг нэгж эрхийг 1.31 тэрбум төгрөгөөр, өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.25 сая ширхэг бондыг 462.83 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.31 сая ширхэг дотоодын үнэт цаасыг 127.81 тэрбум төгрөгөөр тус тус арилжааллаа. Тайлант хугацаанд өдөрт дунджаар 6.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.15 сая ширхэг үнэт цаас арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. - Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа: 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 515 удаагийн цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсанаас 441 арилжааны хэлцэл амжилттай хийгдэж, нийт 17.70 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 5.90 их наяд төгрөгөөр арилжааллаа. Үүнээс "Андын Илч ХХК", "Монголын Алт (МАК) ХХК", "Мөнх тэнүүн оргил ХХК", "Саусгоби Сэндс ХХК", "Тавантолгой ХК", "Хангад Эксплорэйшн ХХК", "Энержи Ресурс ХХК", "Эрдэнэс Тавантолгой ХК" нь 14.60 сая тонн нүүрсийг 4.80 их наяд төгрөгөөр, "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК", "Эрдэнэс критикал минералс ТӨҮГ /Монголросцветмет ТӨҮГ" нь 3.05 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 688.93 тэрбум төгрөгөөр, "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ" нь 40.0 мянган тонн зэсийн баяжмалыг 409.55 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна - Шинэ бүтээгдэхүүн: Тайлант хугацаанд "Инвескор өсалт ТЗК" ХХК-ийн 50.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 500,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Нийслэлийн Засаг даргын нийтэд санал болгосон 200.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 200,000 ширхэг бонд, Өмнөговь аймгийн Засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгосон 150.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 100,000 ширхэг бонд болон Засгийн газрын дотоодын үнэт цаасны 125.92 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1,300,000 ширхэг бондын анхдагч зах зээлийн арилжааг тус тус амжилттай зохион байгуулав. 2026 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр 162 ХК-ийн хувьцаа, Засгийн газрын 52 бонд, Аймаг,
--	--

		нийслэлийн засаг даргын 4 бонд, 5 компанийн 10 бонд, 3 хөрөнгө оруулалтын сан, 3 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлтэй байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
3.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл,	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.
4.	Үнэт цаас гаргаагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	

6.	Компанийн засаглалтай хобоотой мэдээлэл
----	---

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2026 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Д.Тогтохбаяр, Ж.Цогтбаяр, Ж.Бямбасүрэн, Т.Ганбаатар, С.Баянцогт, Р.Мөнхтөр, Н.Улаанхүү, Н.Отгончимэг, М.Банзрагч нарыг чөлөөлж Б.Болормаа, Ш.Бат-Эрдэнэ, Г.Гийхнаран, Т.Ганбаатар, Л.Энхбаяр, Н.Отгончимэг, П.Баяр, Х.Булгантамир, Ж.Золзаяа шинээр томилсон байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2023 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2023 оны 05 дугаар сард шинээр томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан мэдээлэл

ТУЗ нь 2026 оны эхний хагас жилд нийт 7 удаа хуралдаж Компанийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Үнэт цаасны арилжаатай холбоотой журам батлах, Уул уурхай, Үнэт цаасны арилжааны брокерт гишүүнчлэл олгох, Дахин үнэлэх, актлах хөрөнгийн талаар дүгнэлт гаргах зэрэг нийт 18 асуудлыг хэлэлцэж, 26 шийдвэр гаргасан. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 4 удаа хуралдаж, 7 асуудлыг хэлэлцсэн, нэр дэвшүүлэх хороо нь 3 удаа хуралдаж, 3 асуудлыг хэлэлцсэн, цалин урамшууллын хороо нь 2 удаа хуралдаж, 2 асуудлыг хэлэлцсэн байна.

8. Ногдол ашгийн мэдээлэл


Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 43.44 төгрөгөөр тооцон, нийт 15,224,136,134.16 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан.

Тус шийдвэрийн дагуу 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан татварын дараах 4,897,759,946.43 төгрөгийг 11,339 хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулж, компанийн 66% эзэмшигч Сангийн яам буюу улсын төсөвт 10,047,929,859.84 төгрөгийн ногдол ашгийг тус тус шилжүүллээ.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.МӨНХБАТ

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гарын үсэг: 

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.ХАНГАЛ

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн захиргааны мэргэжилтэн

Гарын үсэг: 